**Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны**
**Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зөвлөх**
**сонгон шалгаруулах зар**

**Төслийн нэр:** Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж (Цахим хоршоо төсөл)

**Ажлын байрны нэр:** Мэдээллийн технологийн зөвлөх

**Ажлын байрны тодорхойлолт: хавсаргав**

**Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хугацаа, хэлбэр:**

Сонгон шалгаруулалтад оролцох иргэний материалыг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 7-ны өдрийн 23:59 цаг хүртэл хүлээн авна. Хүлээн авах имэйл хаяг: **vpia.procurement3@gmail.com**

**Бүрдүүлэх материал:**

i. Өргөдөл
ii. Анкет
iii. Дипломын хуулбар
iv. Өмнө нь ажиллаж байсан 2 байгууллагын тодорхойлолт

**Анхаарах зүйлс:**

- Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирүүлсэн иргэдийн материалын бүрдэл (дутуу тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна)
- Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй.
- Шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулга авч болно.

## АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| 1. Гэрээний дугаар: CS-ICS-PMU-C3-01/2025 | 2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| 3. Төсөл, арга хэмжээний нэр, дугаар: Цахим хоршоо төсөл, TF0C2460 | 3.1. Орон тоо, албан тушаал: Мэдээллийн технологийн зөвлөх |
| 4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн зохицуулагч болон дэд зохицуулагч | |

Б.ЧИГ ҮҮРЭГ

| | | | |
|---|---|---|---|
| 1. Ажлын байрны үндсэн зорилго: | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэгч нарыг дэмжихэд чиглэсэн хөдөө аж ахуйн бүтээмж, зах зээлийн хүртээмжид олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нөөц, үйлчилгээнд нэвтрэх цахим платформыг боловсруулах, хэрэгжүүлэх, удирдах ажлыг хариуцна. | | |
| 2. Ажлын байрны дэд зорилтууд: | 1. Цахим платформын төлөвлөлт, хэрэгжилтийг хангах.<br>2. Тариаланчид, малчид, төрийн байгууллагууд, ТББ-ууд зэрэг оролцогч талуудыг цахим платформд нэвтрүүлэх, тэдгээрийг чадавхжуулах<br>3. Мэдээллийн технологийн хэвийн үйл ажиллагааг хангах, оролцогч талуудыг мэдээллээр хангах | | |
| 3. Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа: | | Хугацаа, хуваарь | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт |
| Ажлын байрны 1 дүгээр зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажил үүрэг: | | | |
| 1.1. Цахим платформын төслийг боловсруулахаас эхлээд ашиглалтад оруулах хүртэл төлөвлөлт, гүйцэтгэлийг удирдан чиглүүлнэ.<br>1.2. Тариаланчид, малчид, төрийн байгууллагууд, ТББ-ууд зэрэг оролцогч талуудтай хамтран шаардлага цуглуулж, платформ нь хэрэглэгчдийн нийгэмлэгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах.<br>1.3. Платформын архитектурын дизайн, боловсруулалтыг хянах, өргөтгөх, аюулгүй байдал, хэрэглэгчдэд ээлтэй байдлыг хангах.<br>1.4. Зах зээлийн мэдээлэл, цаг агаарын урьдчилсан мэдээ, хөдөө аж ахуйн шилдэг туршлага, цахим худалдааны чадавх зэрэг төрөл бүрийн үйлчилгээг платформд нэгтгэх ажлыг удирдана.<br>1.5. Цахим платформыг нөхөх гар утасны аппликейшн болон SMS үйлчилгээг хөгжүүлэхийн тулд техникийн багуудтай хамтран ажиллах.<br>1.6. Платформын хэрэглээ болон нөлөөллийг хянахын тулд өгөгдлийн удирдлага, аналитик системийг нэвтрүүлэх. | | Байнга | Байнга |
| Ажлын байрны 2 дугаар зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажил үүрэг: | | | |

| | | |
|---|---|---|
| 2.1. Өгөгдлийн хамгаалалт, нууцлалын талаарх холбогдох дүрэм журам, стандартыг дагаж мөрдөх.<br>2.2. Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж, хэрэглэгчид болон орон нутгийн дэмжлэг үзүүлэх багуудад чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулах.<br>2.3. Платформын гүйцэтгэлийг хянаж, үнэлж, шаардлагатай бол функциональ байдал, хэрэглэгчийн туршлагыг сайжруулахын тулд тохируулга хийх.<br>2.4. Платформын төсвийг удирдах, нөөцийг үр ашигтай ашиглах, төслийн зорилгод нийцүүлэх | Байнга | Байнга |
| Ажлын байрны 3 дугаар зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажил үүрэг: | | |
| 3.1. Цахим платформын программ хангамж хөгжүүлэлт, мэдээллийн баазын удирдлагын хэвийн ажиллагааг хангах, түүнд хяналт тавих.<br>3.2. Цахим платформын хөгжүүлэлттэй холбоотой өөрчлөлт шинэчлэлийг оролцогч талуудад мэдээлэх<br>3.3. Цахим платформ болон гэрээт ажлын гүйцэтгэлд тайлан мэдээ өгөх. | Байнга | Байнга |
| Тайлбар: Ажилтны ажил үүрээ гүйцэтгэх хугацаа, хуваарийг төсөл, арга хэмжээний тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно. | | |

В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

| | | Үзүүлэлт | Чухал шаардлагатай | Шаардлагатай |
|---|---|---|---|---|
| 1. Ажлын байранд тавигдах шаардлага | 1.1. Ерөнхий шаардлага: | Боловсрол | Дээд | |
| | | Мэргэжил | Компьютерын шинжлэх ухаан, Мэдээлэл, харилцаа холбооны технологи эсвэл холбогдох чиглэлээр магистрын зэрэгтэй | |
| | | Туршлага | Мэдээлэл технологийн төслийн менежментийн чиглэлээр хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслүүдэд 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. | Программ хангамж хөгжүүлэлт, мэдээллийн баазын удирдлага, тооцоололд ажиллаж байсан туршлагатай, техникийн өндөр мэдлэгтэй байх. |
| | | | Харилцаа холбоо болон сургалт удирдан зохион байгуулах ур чадвартай байх | |
| | | | Ажлын ачаалал даах, бие даан ажиллах ур чадвартай байх | |
| | | | Бүх түвшний оролцогч талууд тэр дундаа малчид, төрийн байгууллагын ажилчид, дотоодын болон олон улсын байгууллагын ажилчидтай үр дүнтэй | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | харилцаа холбоо тогтоох чадвартай байх | |
| | | | Багаар ажиллах чадвартай байх | |
| | | | Монгол болон Англи хэлний ярианы болон бичгийн мэдлэгтэй байх | |
| | 1.2. Тусгай шаардлага: | - Жендерийн асуудлыг бодлого, төлөвлөлтөд хэрхэн тусгах талаар мэдлэгтэй байх<br>- Ажлын ачаалал даах чадвартай<br>- Орон нутагт томилолтоор ажиллах боломжтой байх | | |